

ОЛИМПИЙН БЭЛТГЭЛИЙН ТОГТОЛЦОО (Норвегийн өндөр зэрэглэлийн тамирчин бэлтгэх жишээн дээр)

Ч.Зоригтбаатар, дэд профессор Н.Бүрэлгүүбадам, магистр

Аннотация: Крайне слабое выступление спортсменов Норвегии на Играх XXIII Олимпиады 1984 г. В Лос-Анджелесе, необходимость кардинальной реорганизации элитного спорта в Норвегии и подготовки спортсменов этой страны к Олимпийским Играм стала неизбежной (Hanstadt, D6V6 2002, x.15). В основу реорганизации было положено обобщение опыта олимпийской подготовки в СССР и ГДР – странах, имевших в те годы подавляющее преимущество на Олимпийских Играх, особенно зимних. В результате совместных предложений НОК Норвегии и Конфедерации национальных спортивных федераций появился проект реорганизации норвежского спорта высших достижений под лозунгом “Элитный спорт, основанный на знаниях”. Основным положением этого проекта стало создание в течение 1988 г. Мощной общественной организации, на которую была возложена ответственность за развитие спорта высших достижений, подготовку и участие спортсменов Норвегии в Олимпийских Играх. Эта организация, которая получила название Olympiatoppen (OLT), была сформирована Национальным олимпийским комитетом и Конфедерацией спортивных федераций, при правительственной поддержке. Задача OLT стала координация деятельности национальных спортивных федераций, отбор наиболее талантливых спортсменов и обеспечение им всех необходимых условий для полноценной подготовки, развитие созданного в Осло Центра подготовки спортсменов специалистов высшей квалификации в дисциплинах, способных повысить качество подготовки спортсменов-физиологии, биохимии, морфологии, психологии, диетологии, физиотерапии и др.

Түлхүүр үг: Олимпийн наадам, спортын амжилт, спортын хөгжил, бэлтгэлийн санжүүжилт, материаллаг бааз,

Удиртгал

Яагаад өндөр зэрэглэлийн спортын зохион байгуулалтын талаар бичих болсон бэ? Өнөө цагт ихэнх оронд олимпийн спортын төрлүүд эрчимтэй хөгжиж байна. Олимпийн наадам болоод өнгөрсөн хэдий ч улс орон дараагийн олимпид бэлтгэх олон жилийн дасгалжуулалтын төлөвлөлтийг боловсруулах ажлыг өөрийн орны өв уламжлал, газар нутгийн онцлог, нийгэм эдийн засгийн тогтолцоо, техник технологийн хангамж, тухайн спортын хөгжлийн түвшин, дасгалжуулалтын орчин үеийн чиг хандлагад тулгуурлан төлөвлөж эхлээд байна. Олимп нь хүн төрөлхтнийг эв нэгдэлтэй болгож, хүний хүчин чадал, нөөц бололцоо хязгааргүй гэдгийг харуулдаг эх дэлхийн бүх хүмүүсийн баяр наадам төдийгүй спортын бүхий л төрлөөр бөмбөрцгийн хамгийн хүчтэй, хурдтай өндөр зэрэглэлийн тамирчид өрсөлддөг спортын хамгийн том тэмцээн билээ. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ Норвегийн өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх тогтолцооны туршлагын талаар өгүүлэх болно. Норвеги нь Скандинавын хойгийн орнууд(Скандинавын хойгийн орнуудад

Норвеги, Швед, Финлянд, Дани зэрэг улсууд багтдаг) дотроос хүн амаараа хамгийн цөөнтэй (4,5 сая хүрэхгүй хүнтэй), харин спорт нь баялаг түүхтэй, эртнээс уламжлалтай, өндөр амжилт үзүүлсэн тамирчин олонтой билээ. Норвеги улсад спортын олон төрлүүдээс өвлийн олимпийн наадмын хөтөлбөрт орсон спортын төрлүүд хүчтэй хөгжсөн. Норвегичууд XX зууны эхээр өвлийн спортын төрлөөр лидер нь байж чадсан. Хамгийн анхны зургаан өвлийн олимпийн наадмын дөрөвт нь Норвегичууд албан ёсны бус багийн дүнгээр тэргүүлж нэг удаа Америкчуудын ард хоёрдугаар байрт орсон түүхтэй. Лос Анжелесийн олимпоос Норвегичууд нэг мөнгөн медаль, хоёр хүрэл медаль авч алтан медальгүйгээр олимпийг дуусгасан. Эндээс тухайн үеийн Норвегийн өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх тогтолцоо учир дутагдалтай байна хэмээн дүгнэснээс гадна олимпийн наадамд оролцох тамирчдыг бэлтгэх тогтолцоог үндсээр нь өөрчлөж, шинэчлэх цаг нь болсон гэдгийг дахин дахин сануулсан сануулга байлаа. (Hanstad D.V, 2002,x.17). Олимпийн

наадамд ялангуяа өвлийн наадамд гайхалтай амжилт үзүүлсэн ЗХУболон БНАГУ-ын олимпийн бэлтгэлийн туршлагаас суралцахад ихээхэн анхаарлаа хандуулсан шинэчлэлийг хийсэн байна. Эцсийн дүнд Норвегийн ҮОХ болон Үндэсний спортын холбоодын зөвлөлөөс хамтран **“Мэдлэг дээр тулгуурласан элит спорт”** гэсэн уриа бүхий Норвегийн өндөр зэрэглэлийн спортын тогтолцоог өөрчлөн шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

Үндсэн хэсэг

Өндөр зэрэглэлийн тамирчдын олон жилийн бэлтгэл, шатлал.

Норвегийн спортын олон жилийн тогтолцоо нь хэд хэдэн үеэс бүтдэг бөгөөд үе бүр нь заавар, удирдлага, төрөл бүрийн санхүүжилтийн үүсвэр, тусгай зохион байгуулалттай. *Нэгдүгээр үе:* 7-8, 12-13 хүртэлх насны хүүхдүүд амьдарч байгаа харьяаныхаа спортын клубд хамрагдаж бэлтгэл хийнэ. Ийм клубүүд Норвегид олон байдаг бөгөөд тэд эцэг, эх болон орон нутгийн засаг захиргааны идэвхтэй оролцоотойгоор үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулна. Олонх хүүхэд эцэг, эхийнхээ тусламжтайгаар (санхүүгийн) хүүхдийн спортын төрөлд хамрагдаж, спортын өндөр амжилт гаргахын төлөө тэмүүлдэг байна.

Хоёрдугаар үе: 12-14, 14-16 хүртэлх насны хүүхдүүд хамрагдана. Тэд өөрийн клубдээ үргэлжлүүлэн бэлтгэлээ хийж, тэдний бэлтгэлд үндэсний спортын холбоо оролцож, авьяаслаг хүүхдүүдийг сонгож тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлж эхэлдэг. Үндэсний спортын холбоо нь ирээдүйд өндөр амжилт гаргах өсвөр насныхныг сонгон шалгаруулж орон нутгийн шигшээ багт мэргэжлийн дасгалжуулагчийнудирдлагандбэлтгэл хийлгэдэг. Энд өндөр зэрэглэлийн тамирчидтай уулзах, туршлагаас нь судлах, зөвлөгөө авах боломж бүрддэг. Үндэсний спортын холбоо нь хотын болон орон нутгийн хэмжээнд олон төрлийн тэмцээн уралдаан болон үндэсний аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулдаг.

Гуравдугаар үе: 17-19 насны хүүхдүүд хамрагдах бөгөөд спортын болон ерөнхий эрдмийн хичээлтэй хослуулан суралцуулах мэргэжлийн сургалттай спортын тусгай дунд сургуульд хичээллэдэг. Эндээс үндэсний спортын холбоо нь жил бүр хүчтэй, авьяаслаг, ирээдүйтэй тамирчин-сурагчдыг Норвегийн залуучуудын шигшээ багт сонгон шалгаруулж авдаг. Жишээ нь: цанын спортын шигшээ багт жил бүр 6 охид, 6 хөвгүүдийг авдаг байна. Энэ үеэстэднийг цугларалтад

хамруулах, мэргэжлийн дасгалжуулагч, эмч нараас дэмжлэг туслалцаа авах, орчин үеийн техник хэрэгслээр хангаж өгдөг. Мөн тэмцээнд оролцож дадлага, туршлага хуримтлуулах боломж нь улам өргөжнө.

Дөрөвдүгээр үе: Дунд сургуулиа төгсөөд их, дээд сургуульд элссэн шилдэг оюутан-тамирчид хамрагдана. Эдгээр тамирчид нь Olympiatoppen (OLT)-ийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд бэлтгэл хийж улсын шигшээ багийг бүрнэлдүүлнэ. Olympiatoppen (OLT) хэмээн нэрлэгдэх болсон энэхүү байгууллага Норвегийн засгийн газрын дэмжлэгтэйгээр спортын холбоодын эвлэл болон Үндэсний Олимпийн Хорооны шууд оролцоотойгоор бүрэлдэн бий болсон. Olympiatoppen OLT-ийн гол зорилго нь Үндэсний Спортын Холбоодын үйл ажиллагааг зохицуулах, өсөх ирээдүйтэй, авьяаслаг тамирчдыг сонгон шалгаруулж, тэднийг бэлтгэл хийхэд хэрэгтэй бүхий л нөхцөл бололцоогоор хангана. Энэ байгууллага 1986 онд Осло хотноо байгуулагдсан. Тамирчдын бэлтгэлийн төвийн үйл ажиллагааг сайжруулан, бэлтгэл, сахилга бат, мэргэжил, боловсролоо дээшлүүлж байгаа зэрэгт анхаарлаа хандуулахын зэрэгцээ, тамирчдын бэлтгэлд шууд нөлөөлдөг физиологи, биохими, морфологи, сэтгэл зүй, хооллолт, физик эмчилгээний чанарыг дээшлүүлэхэд чухал шаардлагатай олон асуудлыг хариуцан ажиллана (Augestad P, 2008, х.32).

Тавдугаар үе: Үндэсний спортын холбоо болон Olympiatoppen (OLT)-ийн хамтын үйл ажиллагааны спортын төрлийн хүрээнд бэлтгэдэг тамирчид дулсын шигшээ багт хичээллэнэ.

Тамирчдыг сонгох үйл явц

Норвегийн орчин үеийн спортын тогтолцоо нь олимпийн наадамд өндөр амжилт гаргах, спорт өндөр хөгжсөн орнуудын түвшинд тамирчдыг бэлтгэх, олимпийн бэлтгэлийг чанартай зохион байгуулахад чиглэгдэж байна. Норвегийн олимпийн бэлтгэлийн тогтолцооны чухал хэсэг үндэсний онцлогтоо тулгуурладагт оршино. Үүний нэг жишээ нь спортын сонголттой нягт холбоотойгоор авьяаслаг хүүхдүүдийг эхнээсээ сонгож спортод 13 хүртэлх насны хүүхдүүдийг хамруулж байна. Энэ насныхны боломжтой бүх хүүхдүүдийг спортод хамруулж, биеийн тамирын холбоотой бүхий л асуудлуудыг шийдвэрлэж, эрүүл амьдралын хэв маягийг хангах зэрэг асуудлыг бодлогоороо хэрэгжүүлдэг. Тухайлбал, 10 хүртэлх насны хүүхдүүдийг нэг төрлийн спортод мэргэшүүлж, дараа нь төрөл бүрийн

спортыг сонгож хичээллэх боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр 11-13 насандаа олонх хүүхдүүд ямар төрлийн спортоор дагнаж хичээллэхээ аль хэдийнээ сонгосон байдаг.

Тамирчдын бэлтгэл хийх бололцоог зохицуулах

Норвегийн спортын тогтолцоонд хүний амьдралын өвөрмөц хэв маягийг хоногийн 24 цагийг спорттой холбоотойгоор авч үздэг байна. Үүнд: бэлтгэл хийхэд зориулж өдөр бүр 4-6 цаг, жилийн 100-120 өдрийг цугларалт, тэмцээн уралдаан, үлдсэн хугацааг дунд, дээд боловсрол эзэмшихэд болон нийгмийн өдөр тутмын амьдралд зарцуулдаг хэмээн үздэг. Спортын судлаач, мэргэжилтэнүүд спортына амжилтын чухал хүчин зүйлийн нэг нь амжилт гаргахыг эрмэлздэг, амжилт гаргахын төлөө нэг зорилго, сонирхол, тэмүүлээр нэгдсэн тамирчдын хэсэгт нэгдэх боломжийг нь бүрдүүлэх хэмээн үздэг. Тиймээс шаардлагатай орчинг бүрдүүлж, эрчимтэй бэлтгэл хийлгэх асуудлыг шийдвэрлэж, эрүүл амьдралын хэв маягийг мөрдөх дэглэмийн сургалт зохион байгуулдаг байна. Мөн залгамж халаа тамирчдыг тасралтгүй бэлтгэх зорилгоор спортын дунд болон их, дээд сургуулийг тусгайлан байгуулсан. Ингэснээр дунд сургуулийн төгсөгчдөд болон их, дээд сургуулийн оюутнуудад боловсрол олгох, бэлтгэл хийх үйл ажиллагааг хослуулан өндөр амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлж ирээдүйн сайн тамирчдыг бэлтгэдгээс гадна тамирчин болох боломжийг нээлттэй олгож байна. Мөн их, дээд сургуулиуд шилдэг тамирчдыг бэлтгэх зорилгоор тусгай сургалтын төлөвлөгөө боловсруулж, хичээл, сурлага болон бэлтгэлийн үйл явцыг холбон явуулах тал дээр анхаарч ажиллан сургалт-дасгалжуулалтад тасралтгүй хамрагдах цугларалтад гарах, тэмцээн уралдаанд оролцох бололцоог хангах үүднээс тусгай хуваариар хичээлдээ явах боломжийг бүрдүүлж өгдөг байна. Энэ нь их, дээд сургуульд суралцаж буй оюутан-тамирчид суралцахын зэрэгцээ спортод өндөр амжилт үзүүлэх боломжийг бүрдүүлдэг. Olympiatopen (OLT) нь дунд сургууль, их, дээд сургуульд суралцагч тамирчдын асуудлыг хариуцаад зогсохгүй, тэдэнд хичээлийн хөтөлбөрөө өөрийн болгоход нь туслах багш нараар хангаж өгөх ажлыг зохион байгуулж, санхүүгийн туслалцаа үзүүлнэ. Olympiatopen (OLT) нь энэ үйл ажиллагааг хэрэгжүүлээд 30 жил болж байна. Тухайлбал, 1978 онд Норвегийн Засгийн газраас Үндэсний Олимпийн Хороонд 300 мянган крон

тамирчдад зориулж гаргаж өгсөн. Энэ цагаас эхлэн жил ирэх тусам энэ санхүүжилт өссөөр 13 сая крон (2 сая америкийн доллар) болсон. Шилдэг тамирчин жил бүр "А" цалин 100 мянган крон (ойролцоогоор 16 мянган америк доллар), харин залуу тамирчин "Б" цалин 50 мянган крон (ойролцоогоор 8 мянган америк доллар) авдаг. Олимпийн наадамд бэлтгэх бүрэлдэхүүнд багтдаг ойролцоогоор 200 тамирчин энэхүү санхүүжилтийг авдаг байна.

Үүнээс гадна зарим тамирчин янз бүрийн байгууллагаас цалин авдаг (Augestand P, 2008, х.19).

Санхүүжилт

Olympiatopen (OLT)-ийн үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь олимпийн наадамд амжилт гаргах шилдэг тамирчдад болон үндэсний спортын холбоодод үзүүлэх мөнгөн болон бусад тусламжийн асуудлыг хариуцан ажилладаг. Сургалт-дасгалжуулалт, тэмцээнд оролцох үеийн шаардлагатай хөрөнгө мөнгөний 50%-ийг Засгийн газраас тэтгэлэг хэлбэрээр олгож, үлдэх хэсгийг нь Норвегийн Үндэсний Олимпийн Хороо (NHOX)-ны орлого, спорт холбоодуудад ивээн тэтгэгчдийн өгч байгаа хандив, тэмцээнийг дамжуулах эрхийг худалдах болон арилжааны бусад хэлбэрээр олдог байна (Bergsgard N.A, 2005, х.21). Тамирчдын сураглт-дасгалжуулалтад хангалттай хөрөнгийн эх үүсвэрийг арилжааны шугамаар олж чадахгүй байгаа холбоодуудад улсаас олгодог тэтгэлгийн 70%-ийг хуваарилан өгдөг бол өөрийн нөөц, бололцоог ашиглан олимпийн наадамд тамирчдаа бүрэн бэлтгэж оролцуулж чаддаг спортын холбоодуудад улсаас өгч байгаа тэтгэлгийн 10%-ийг олгодог (Enjolras B, 2004, х.23).

Материаллаг баазын хангамж

XX зууны 80-аад онд Норвегийн засгийн газар спортыг эрчимтэй хөгжүүлэх зорилгоор спортын баазийг хөгжүүлэх, сургалт-дасгалжуулалт, тэмцээн уралдааныг олон улсын түвшинд зохион байгуулах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлсэн. Спортын үйл ажиллагаанаас цуглуулсан хөрөнгөөр олон спортын ордон байгуулсан.

Мөн олон улсын тэмцээн зохион байгуулах хэд хэдэн томоохон байгууламжийг бүтээн босгосон (Augestand P, 2008, х.25). Тронхейм хот нь (Норвегийн хоёрдахь том хот) Норвегийн өвлийн спортын үндэс суурыг өргөжин тэлэхэд маш ихээр нөлөөлсөн. Норвегийн засгийн газар XXII

өвлийн олимпийн наадмыг (2018 он) Норвегийн (Осло, Лиллехаммер, Тронхейм, Тромсе) аль нэг хотод зохион байгуулах зорилготойгоор ажиллаж байна. 1986 онд Осло хотноо байгуулсан спортын төвийг үндсэн төвөө болгож 1990 онд Олимпийн наадамд оролцох тамирчдын бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх цогцолбор төв болгох талаар шийдвэр гаргасан. Тус төвийн үндсэн онцлог нь тамирчдад нэгдсэн үйлчилгээ үзүүлэх, тамирчин олон төрлийн бэлтгэл хийх, хөтөлбөр боловсруулж өөрсдийгөө хөгжүүлэх, гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тусгай дэглэм боловсруулах гэх мэт юм.

Ирээдүйн тамирчдыг бэлтгэх үндсэн төв бөгөөд спортын шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг явуулж үр дүнг нь шилдэг тамирчин бэлтгэхэд хэрэгжүүлж ирсэн. Энэхүү төвүүд нь төрийн мэдэлд харьяалагдаж,

тамирчинтай гэрээгээр ажилладаг тогтолцоотой. Олимпийн наадмын бэлтгэлийн үндсэн гол чиглэл нь XX зууны 80-аад оны сүүлчээр тавигдаж, хамгийн орчин үеийн шинэ техник хэрэгсэл ашиглаж ирсэн. Жишээ нь: Цанын гулсалтыг сайжруулах гэх мэт. Эндээс гарсан зэрэг сайн үр дүнг элүүрт завь, далбаат завь гэх зэрэг янз бүрийн спортын төрлүүдэд ашигласан (Augestad P, 2008, х.26). Olympiatoppen (OLT)-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил нятасралтгүй өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэхэд чиглэгдэж байна. Эрдэм шинжилгээ, судалгааны хөтөлбөрүүдэд тусгай дэглэм боловсруулах ажил чухал байр суурийг эзэлдэг. Үүнд шингэн хэрэглэх хэмжээ, төрөл бүрийн хоолны нэмэгдэл зэрэг олон зүйл хамаарна.

Судалгааны үр дүн янз бүрийн спортын төрөлд мэргэшсэн тамирчдад зориулан биеийн хүндийг тохируулах, өөхөн эд болон булчингийн харьцаа, бодисын солилцоог зохицуулах, сэргээх зэрэгт чиглэгдэн хэрэгжүүлдэг (Augestad P, 2008, х.26). Olympiatoppen (OLT) нь материалын болон санхүүгийн асуудлыг шууд хариуцдаг байгууллага болсноор богино хугацаанд хуучин БНАГУ-д, одоо БНХАУ-д хэрэгжиж байгаа олимпийн наадамд тамирчдыг бэлтгэх арга, туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж чадсан байна.

Ингэснээр цаг хугацааны энэ л үед Норвегийн тамирчдын олимпийн наадамд амжилт гаргах нөхцөл бололцоог хангах, өндөр зэрэглэлийн спортын хөгжлийн асуудалд ихээхэн дэвшил гаргаж чадсан. Норвегийн Засгийн газар элит спорт руу илүү их анхаарлаа хандуулсан, материаллаг болон санхүүгийн дэмжлэгийг жилээс жилд улам өсөн нэмэгдүүлсэн нь амжилт

гаргахад жинхэнэ түлхэц болсон байна. Норвегийн засгийн газрын баримталж байгаа бодлого нь “спорт бүх нийтийн үйлс” гэж үзэж хүүхэд, өсвөр үеийнхний спортыг дэлхийн аль ч улс оронд байхгүйгээр өндөр түвшинд хөгжүүлэхээр зорилго тавин ажиллаж байна. Энэ нь ихээхэн үр дүнд хүрч байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд спорт нэгэн жигд хурдацтай хөгжиж байна.

Спортын хөгжилд нэгдүгээрт: материаллаг баазын хөгжил; хоёрдугаарт: спортын бэлтгэлийн санхүүжилтийн асуудал чухал байр суурийг эзэлж байна.

Олимпийн наадамд амжилт гаргах хамгийн гол арга нь өөрийн орны түүх, өв уламжлалд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй спортын төрлүүдийг эрчимтэй хөгжүүлэх, дэлхийн тэргүүлэх орнуудын сургалт-дасагалжуулалтын арга туршлагыг цаг алдалгүй нэвтрүүлэхэд оршино.

Дэлхийн спортын аварга том гүрнүүдтэй адил хэмжээнд өрсөлдөхүйц тийм хэмжээний хүн амын нөөц байхгүй ч шинжлэх ухааны үндэслэлтэй сураглт-дасаглжуулалтын арга зүйг амжилттай хэрэгжүүлж, практикт нэвтрүүлэх арга замыг сонгон авах нь өндөр амжилт үзүүлэх бололцоог дээшлүүлнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Бауер, В.Г. (1986). Организационно-методические аспекты совершенствования системы подготовки олимпийских резервов. *Научно-спортивный местник*. №6.

Платонов, В.Н. (2010). Организационные основы спорта высших достижений в Норвегии. Спорт высших достижений и подготовка национальных команд к Олимпийским Играм.

Bergsgard, N.A. (2000). Idrettspolitikkens maktspill. Endring og stabilitet i den Idrettspolitiske styringsmodellen. University of Oslo Rapport